



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/107

Хэрлэн сум

Хөндлөнгийн хяналт хийлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 37 дугаар зүйлийн 37.2, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.2, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 5.5 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 06 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсөв болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгүүлэх зорилгоор барилга угсралт, их засварын ажлын явцад хөндлөнгийн хяналт хийх ажлыг "Хэнтий аймгийн инженер, зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо" Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

2. "Хэнтий аймгийн инженер, зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо" Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Хөндлөнгийн хяналтыг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тухайн хөрөнгө оруулалтын ажлын захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА